



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.


6. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 05 сарын 23 өдрийн
А/33 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2014.05.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Би Ди Би Си ХХК	Ану марал	Баянгол дүүрэг, 9-р хороо, Хасбаатарын гудамж 22

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 05 сарын 23 өдрийн
А/БЗ тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2014.05.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Монгол Киёши ХХК	Тэмүүжин	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Энхтайваны чөлөө 44
2	Алтан наран ХХК	Эрхэс	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3а
3	Алтан наран ХХК	247	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3
4	Ашид инж ХХК	Ашид	Баянгол дүүрэг, 12-р хороо, Өргөө гудамж 7
5	Ти Энд Жи ХХК	Нью вэст	Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө
6	Ундецим Ундецим ХХК	Элеганс	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж 16/3
7	Тахилга ХХК	Топаз	Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, Их тойруу 34/1

-ooOoo-

A/33

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 05 сарын 23 өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
ЖАГСААЛТ

2014.05.23


Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Бумбат хайрхан ХХК	Даймонд	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 30/1
2	Иргэн А.Эрдэнэчимэг	Такара	Баянгол дүүрэг, 22-р хороо, 18/30
3	Иргэн Ц.Чинзориг	Хан хөхий	Баянзүрх дүүрэг, 27-р хороо, Дарь эхийн 5 д
4	Иргэн Р.Нянтайсүрэн	Бэрс	Баянгол дүүрэг, 16-р хороо, Орхоны 2/7

-ooOoo-

A/33

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 05 сарын 03 өдрийн
тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2014.05.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эс-Пи Сервис ХХК	Сансар	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 15-р хороолол АҮ төв
2	Манкур ХХК	Манкур	Баянгол дүүрэг, 16-р хороо, Туулын 19-386
3	Металл Сервис ХХК	Их наяд	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 36а

-ooOoo-